

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 14.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 3, 4, 5 дахь хэсэг, Тайлбар нэмсүгэй:

1/14.4 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг:

“3.Шашны байгууллагын үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн, эсхүл шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг зөвшөөрөлгүй байгуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Шашны байгууллага:

4.1.улс төрийн нам болон улс төрийн хөдөлгөөний үйл ажиллагаанд оролцсон, улс төрийн үйл ажиллагаанд эд материалын болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлсэн;

4.2.шашны нэр хүнд, хүн амын сүсэг бишрэлийг ашиг олох болон улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хангах зорилгод нийцүүлэн ашигласан;

4.3.зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрээс гадна үйл ажиллагаа явуулсан;

4.4.зөвшөөрөлгүйгээр дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл нэр, байршлаа өөрчилсөн;

4.5.гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянга дөрвөн зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

5.Шашны номлол түгээгч, шашны бүлэг энэ зүйлийн 4.1, 4.2-т заасан үйл ажиллагаа явуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

“Тайлбар:- Энэ хуульд заасан “харгис, хүмүүнлэг бус шашин” гэж гэж дайн, террорист үйл ажиллагаа, хэт даврах буюу экстремист үйл ажиллагаа, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, ялгаварлан гадуурхах, хүний амь нас, эрүүл мэндийг хохироох зэрэг хууль зөрсөн хэлбэрээр зан үйл, ёслол үйлддэг, бусад шашныг үгүйсгэх, шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалдаг, номлодог шашны урсгал, чиглэлийг ойлгоно.”

2 дугаар зүйл: Эрүүгийн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “учруулахаар сүрдүүлж” гэсний дараа “шашны номлол түгээгч, шашны бүлэг,” гэж, мөн хэсгийн “зан үйл” гэсний дараа “, ёслол үйлдэх, шашны үйл ажиллагаанд оролцох, шашны байгууллагад гишүүнээр элсэх, гишүүнээс татгалзахад саад учруулсан, эсхүл шашны үйл ажиллагаанд хандив өгөхийг албадсан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шашны харгис үзэл номлолыг сурталчилсан” гэснийг “харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг түгээн дэлгэрүүлсэн” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “зан үйл” гэсний дараах “үйлдэхэд” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “номлол түгээгч” гэсний өмнөх “төлөөлөгч,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15.22 дугаар зүйлийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/15.22 дугаар зүйл:

“15.22 дугаар зүйл.Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль зөрчих

“1.Шашны бүлэг нь гишүүн бус этгээдээс хандив, санхүүгийн дэмжлэг авсан, олон нийтэд шашин түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Шашны байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг дүрэмд зааснаас өөр зорилгоор зарцуулсан, орлогоос урамшуулал, ашиг хуваарилсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Шашны номлол түгээгч, шашны бүлэг, шашны байгууллага нь:

3.1.хүүхдийн хүсэл зоригийн эсрэг, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр шашны үйл ажиллагаанд оролцуулсан, шашны сургуульд элсүүлсэн, шашны сургалтанд хамруулсан, эсхүл суурь боловсрол эзэмшихэд нь саад учруулсан;

3.2.гэрлэх, гэрлэлтээ цуцлуулахыг албадах, эсхүл бөөнөөр гэрлүүлэх үйл ажиллагаа явуулсан, уриалсан;

3.3.шашны зан үйл, ёслол үйлдэхдээ байгаль орчинг бохирдуулсан, эсхүл ийм хэлбэрээр шашны зан үйл, ёслол үйлдэхийг номлодог, уриалдаг бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Шашны байгууллагаас бусад этгээд:

4.1.нийтэд зориулсан мөргөлийн газар, том орон зай эзлэх шашны зориулалт бүхий хөшөө дурсгал, суварга байгуулсан;

4.2.нийтэд худалдах, түгээх зорилгоор шашны ном, зохиол, шашны зориулалттай эд зүйлсийг хэвлэсэн, үйлдвэрлэсэн, экспортолсон, импортолсон бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Шашны байгууллагын эрх барих болон гүйцэтгэх удирдлага нь хувь хүн, байгууллагаас хувьдаа хандив авсан бол хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.“

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсгай.

1/15.2 дугаар зүйл:

“15.2 дугаар зүйл.Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль зөрчих:

1.Шашны бүлэг нь гишүүн бус этгээдээс хандив, санхүүгийн дэмжлэг авсан, олон нийтэд шашин түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Шашны байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг дүрэмд зааснаас өөр зорилгоор зарцуулсан, орлогоос урамшуулал, ашиг хуваарилсан бол тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Шашны номлол түгээгч, шашны бүлэг, шашны байгууллага нь

3.1.хүүхдийн хүсэл зоригийн эсрэг, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр шашны үйл ажиллагаанд оролцуулсан, шашны сургуульд элсүүлсэн, шашны сургалтанд хамруулсан, эсхүл суурь боловсрол эзэмшихэд нь саад учруулсан;

3.2.гэрлэх, гэрлэлтээ цуцлуулахыг албадах, эсхүл бөөнөөр гэрлүүлэх үйл ажиллагаа явуулсан, уриалсан;

3.3.шашны зан үйл, ёслол үйлдэхдээ байгаль орчинг бохирдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, эсхүл ийм хэлбэрээр шашны зан үйл, ёслол үйлдэхийг номлодог, уриалдаг бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Шашны байгууллагаас бусад этгээд:

4.1.нийтэд зориулсан мөргөлийн газар, том орон зай эзлэх шашны зориулалт бүхий хөшөө дурсгал, суварга байгуулсан;

4.2.нийтэд худалдах, түгээх зорилгоор шашны ном, зохиол, шашны зориулалттай эд зүйлсийг хэвлэсэн, үйлдвэрлэсэн, экспортолсон, импортолсон бол

хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Шашны байгууллагын эрх барих болон гүйцэтгэх удирдлага нь хувь хүн, байгууллагаас хувьдаа хандив авсан бол хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.“

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Төсөл
Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.7.3 дахь заалтын “шашны байгууллага” гэсний өмнө “шашны бүлэг,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 40.1.6 дахь заалт нэмсүгэй:

“40.1.6.гадаад улсын шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;”

2 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “хүмүүнлэг бус” гэсний өмнө “харгис,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтын дугаарыг “40.1.7” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 3.1.20 дахь заалт нэмсүгэй:

“3.1.20. “шашны бүлэг” гэж Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн 7.1-д заасан байгууллагыг; “

2 дугаар зүйл. Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5.10, 70.5.17 дахь заалтын “шашны байгууллага” гэсний дараа “шашны бүлэг” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“3.1.14.шашны байгууллага” гэж Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн 8.1-д заасан хуулийн этгээдийг;”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг нэмсүгэй:

1/20¹ дүгээр зүйл:

“20¹ дүгээр зүйл. Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамж

20¹.1. Төвлөрсөн шашны байгууллага, төвлөрсөн шашны байгууллагын болон гадаад улсын шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгоход 3.000.000 төгрөг”;

20¹.2. Орон нутгийн шашны байгууллага, орон нутгийн шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгоход 1.000.000 төгрөг”;

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“15.2.3. шашны байгууллага болон шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэхэд 500.000 төгрөг;

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын “40 000” гэснийг “200 000” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

**ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн “сүм хийдийн” гэснийг “шашны байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 13 дахь хэсэг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг:

“13.Ерөнхийлөгч монголын ард түмний эв нэгдэл, соёл, иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэх үүднээс уламжлалт шашны тэргүүнийг ёсчилно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Төр, сүм хийдийн харилцааны” гэснийг “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 хэсгийн “шашны байгууллага” гэсний дараа “шашны бүлэг” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтын “шашны байгууллагын” гэсний өмнө “шашны бүлэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтын “сүм хийдтэй” гэснийг “шашны бүлэг, шашны байгууллагатай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.7 дахь заалтын “сүм хийдийн” гэснийг “шашны бүлэг, шашны байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7/-д заасан “сүм хийдтэй” гэснийг “шашны бүлэг, шашны байгууллагатай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг